**МОНГОЛ УЛС**
**ӨМНӨГОВЬ АЙМАГ**

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

*Төлөвлөгөө тайланг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

***Аймгийн Засаг дарга*** ........................ /Н.ЭНХБАТ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*2025.06.16 (огноо)*

*Тэмдэг..........................*

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

***Эрүүл мэндийн газрын дарга*** ........................ /Ц.Жавзандулам/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*2025.06.16 (огноо)*

*Тэмдэг ............................*

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратегийн зорилго-1: Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх, эрүүл зөв дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд оршино.** | | | | | | | |
| 1.1 | **Зорилт 1.1. Халдварт өвчний тархалт, сэргийлэлт бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авах, дархлаажуулалтын арга хэмжээг хүртээмжтэй болгож, халдварт өвчний тархалтыг бууруулна.** | | | | | | |
| | **Арга хэмжээ 1.1.1** Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Сургалтын тоо<br>Хамрагдсан хүний тоо | - | 10<br>500 | Хүн амын дундаж наслалтыг уртасгах, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг Өмнөговь аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгийн хүрээнд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлээр аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 7 төрлийн төсөл арга хэмжээг тусган шаардлагатай 1.0 тэрбум гаруй төгрөгийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэн ажилласан. Тухайлбал Хавдрын эсрэг арга хэмжээ, Сүү тараг, Эрүүл элэг, Эрүүл-шүд, Эх хүүхдийн эрүүл мэнд дэмжих зэрэг орон нутгийн бодлого хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна.<br>Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай<br>хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг сурталчлан таниулах ажлын хүрээнд Гурвантэс, Ноён, Сэврэй, Ханбогд сумдад сургалт нөлөөллийн цогц арга хэмжээг зохион байгуулан 996 иргэн, төрийн албан хаагчдад мэдээ, мэдээллээр хүргэн ажилласан.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж, 20 байгууллагын 27 эмч, мэргэжилтнийг чадавхжуулж, гэрчилгээ олгосон.<br>2025 оны Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 3 удаагийн судалгаа хийгдэхээр төлөвлөгдөж судалгааны арга зүйг боловсруулж байна.<br>Зохион байгуулсан сургалтын тоо-5<br>Хамрагдсан хүний тоо-1023 | |
| | **Арга хэмжээ 1.1.2** Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх, тандах чиглэл хөтөлбөр, төслийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах | Орон нутгийн төсөв | Халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд | 187,6 | 185 | “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө” -г батлуулан төрийн өмчийн 22 эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 52 үйл ажиллагаа төлөвлөгдсөн хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.<br>Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 5 сарын байдлаар Улаанбурхан өвчний 265 тохиолдол хүүхдийн байгууллагад голомтлон гарч, | 85 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | голомтод ХӨСҮТ-ийн багтай хамтран ажиллаж, зөвлөмжийг боловсролын байгууллагуудад хүргүүлэн ажилласан.<br><br>2025 оны хагас жилийн байдлаар хоол хүнсний шалтгаант хордлого уул уурхай, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг 3 аж ахуй нэгжид голомтлон гарч 468 хүн өвчилсөн. Голомтод мэргэжлийн баг бүрдүүлэн ажиллаж, голомтлон гарсан гэдэсний халдварын үүсгэгч эх уурхайг тодорхойлж, голомтыг таслан зогсоон, зөвлөмж арга зүйгээр ханган ажилласан. Голомтлон гарсан хоол хүнсний шалтгаант хордлогын үед эрүүл мэндийн байгууллагаас хариу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж 2350 гаруй ажилчид, иргэнийг халдвар авах эрсдэлээс таслан сэргийлж, голомтыг цомхотгож ажилласан. МУ-ын Шадар сайдын 2023 оны А/28 дугаар тушаалын дагуу эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг Улаанбурхан, Хоолны хордлогот халдварын үед 4 удаа эрсдэлийн үнэлгээ хийхэд ИХ ЭРСДЭЛТЭЙ, “Идэвхжилийн II зэрэг” үнэлэгдэж, хариу арга хэмжээг төлөвлөн ажилласан.<br><br>Он гараад 795 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 194 тохиолдлоор буурсан байна.<br><br>Халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд 708 буюу 91,9 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 1.1.3. *“Эрүүл элэг”*** хөтөлбөрийг хэрэгжүүлж элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээний хамрагдалтыг нэмэгдүүлж илэрсэн өвчлөлийг эмчилгээнд бүрэн хамруулах, В вирусын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулах | Орон нутгийн төсөв<br>50.0 | Элэгний эрт илрүүлгийн хувь | 60.3% | 70.0% | Эрүүл элэг хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх 3 зорилтын 16 арга хэмжээтэй төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.<br>“Элэг бүтэн монгол” арга хэмжээ, “Эрүүл элэг” орон нутгийн дэд хөтөлбөрийн хүрээнд 15 дээш насны 29871 иргэнийг хамруулахаас 20,6 хувь буюу 6147 иргэнийг эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулж, 0.09% буюу 5 нь С вирустэй, 0.04 % буюу 2 нь В вирусийн архаг шинэ тохиолдлыг илрүүлэн эрүүл мэндийн байгууллагын хяналтад авсан. Цочмог С вирусийн халдвартай 1, В вирусийн халдвартай 1 хүн тус тус бүртгэгдээд байна.<br>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн PCR шинжилгээнд нийт 125 хүн шинжилгээ хийж HCV вирус 36% буюу 45 хүнд ачаалал үзэхэд идэвхгүй 35 (77.8 %) идэвхтэй 10 (22.22%), HBV вирус 33.6% буюу 42 хүнд ачаалал үзэхэд идэвхгүй 33 (78.6%) идэвхтэй 9 (21.4%) , HDV вирус 30.4% буюу 38 хүнд ачаалал үзэхэд идэвхгүй 29 (76.3%) идэвхтэй 9 (23.7%), HBV&HDV хавсарсан вирустэй (0.08 %) хүмүүс хамрагдсан байна. Элэгний С вирусийн эмчилгээнд хамрагдах шаардлагатай 10 иргэнээс 8 иргэнийг эмчилгээнд бүрэн хамруулж, 5 хүн эдгэрсэн байна. Үүнээс жирэмсэн 3 хүн эмчийн хяналтад орсон байна. Элэгний В вирусийн эмчилгээнд 10 хүн шинээр хяналтад орж нийт 35 хүн эмийн эмчилгээнд тасралтгүй хамрагдаж байна. Үүнээс жирэмсэн 1 эх эмчийн хяналтад ороод байна. Элэгний В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 430 хүн тун хийгдэж, үүнээс 94 хүн бүрэн тунд | 20,6 |
| | | | Эмчилгээнд хамрагдалтын хувь | 50.9% | 65% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдаад байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Фиброскан аппарат ашиглалтад орсноос хойш 188 хүнд тусламж үзүүлснээс F1 зэргийн элэгний хатууралтай 2, F2 зэргийн элэгний хатууралтай 3, F3 зэргийн элэгний хатууралтай 5, F4 зэргийн элэгний хатууралтай 4 зэргийн оношлон шаардлагатай тусламж үйлчилгээг хүргэсэн В вируст хепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь -100 хувь буюу 459 хүүхдийг хамруулсан. | |
| | **Арга хэмжээ 1.1.4.** Сүрьеэ өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, эмчилгээнд хамрагдалт, эмчилгээний үр дүнг улирал бүр хянах | Орон нутгийн төсөв | Сүрьеэгийн өвчлөлийн түвшинд 10 000 хүнд | 1,9 | 0,9 | Эрүүл мэндийн яам, Глобаль сан, Сумын эмч мэргэжилтний холбооны дэмжлэгтэйгээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран сүрьеэгийн эрсдэлт бүлгийн хүн амд "Хаалганаас хаалган"-д хүрч үйлчлэх, сүрьеэ өвчнийг эрт илрүүлж, эмчилгээнд хамруулан, тархалтыг бууруулах зорилготой үзлэг арга хэмжээг Баяндалай, Гурвантэс, Ноён, Ханбогд, Цогт-овоо, Цогтцэций сумдын нийт 850 хүнийг хамруулахаас 582 хүнийг хамруулсан. Үүнээс хаалганаас хаалганд очиж хамруулсан хүний тоо 18 байна.<br><br>Асуумж ярилцлагад хамрагдсан хүний тоо 526 хүн буюу эрсдэлт бүлгийн хүн амын 90,3% хамруулсан. Цээжний рентген шинжилгээнд 500 хүн хамрагдсан. Сүрьеэтэй байж болзошгүй 35 тохиолдлыг илрүүлэн молекул биологийн шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний үр дүнд 1 тохиолдлын оношийг баталгаажуулж, эмчилгээнд хамруулсан. | 92,3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сүрьеэгийн өвчлөлийн түвшинд 10 000 хүнд 4 буюу 0,5 промиль түвшинд байна. | |
| | **Арга хэмжээ 1.1.5.** Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, эмчилгээнд хамрагдалт, эмчилгээний үр дүнг улирал бүр хянах | Орон нутгийн төсөв | БЗДХ-т өвчний тохиолдол 10000 хүн амд | 60.8 | 60 | 2025 оны 5 сарын байдлаар нийт 795 халдварт өвчин тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс бэлгийн замаар дамжих халдварт өвчин 261 буюу 32,8 хувийг эзэлж байна. БЗДХ-т өвчний тохиолдол 10000 хүн амд 33,9 промиль байна. Нийт бэлгийн замаар дамжих халдварт өвчний 22,2 хувь нь буюу 58 тохиолдол нь өсвөр насны хүүхдүүд байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3,3 промиль өссөн байна.<br><br>Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 16.5% нь жирэмсний үзлэгээс, 3.8% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 93.5% нь өвчний учир амбулаториор, 2.7% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.<br><br>Бүртгэгдсэн бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс тэмбүү 41%, заг хүйтэн 29.9, хламид 11.5%, трихомониаз 13.4%, бусад халдвар 4.2%-ийг тус тус эзлэж байна. Илрэлсэн өвчлөлийг 100% бүрэн эмчилгээнд хамруулж, хавьтагчийн 30%-ийг илрүүлж эмчилгээнд хамруулсан байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад 3257 хүнд хурдавчилсан сорил хийгдэж эерэг илэрсэн тохиолдлыг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад онош тодруулах болон эмчилгээнд хамруулсан байна.<br><br>ШУТИС-ын Өмнөговь аймаг дахь салбар Техникийн их сургуулийн киос хөтөлбөрийн 81 хүүхдийг халдварт өвчний эрт илрүүлэг шинжилгээнд хамруулж илэрсэн өвчлөл | 85 |
| | | | Илрүүлсэн өвчлөлийг эмчилгээнд бүрэн хамруулсан хувь | 100 | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэгдээгүй байна. Халдварт өвчин судлалын үндэсний төв, Глобал сангийн дэмжлэгтэйгээр БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээ үзүүлэхэд оролцож буй эмнэлгийн мэргэжилтний ажлын ачааллыг тооцох судалгаа үнэлгээнд БОЭТ, Энхийн хүслэн ӨЭМТ, Цогтцэций СЭМТ-г хамруулсан. Мөн ХДХВ-ын халдвартай хүмүүст чиглэсэн хүн төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэлэх" үнэлгээнд БОЭТ, Шимбилэг ӨЭМТ, Хатанзаяат, Түмэн мэлмий эмнэлгүүд хамрагдсан. Үнэлгээний эцсийн дүгнэлт ХӨСҮТ-д хүлээгдэж байна. | |
| | **Арга хэмжээ 1.1.6.** Дархлаажуулалтын хамралтыг орон нутгийн түвшинд нэмэгдүүлэх | Орон нутгийн төсөв | Товлолын дархлаажуулалтын хамралтын хувь | 98.5 | 98.6 | Товлолын вакцины хамралт 95,5%-тай 81 хүүхэд хоцорсон байна.<br>БЦЖ вакцины хамралт-100%, В вируст хепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь -100 хувь буюу 459 хүүхдийг хамруулсан. халдварт саагийн эсрэг вакцины хамралт 98,0 хувьтай, хоцорсон -9. Тарьдаг саа-98 хувьтай хоцорсон-11 хүүхэд байна. Тавт вакцины хамралт-98,1%, хоцорсон-9, А гепатит 98,0%-тай хоцорсон-8, УГУ вакцины хамралт -98,5% хоцорсон-21, ПЕВ вакцины хамралт -98.5 хувьтай хоцорсон 22 хүүхэд байна. Хүний папиллома вирусын эсрэг вакцинжуулалтыг орон нутагт нэвтрүүлж, хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт нөлөөллийн ажлыг 10 сумын ард иргэд, эцэг эхчүүд, сурагчид нийт 2000 гаруй хүнд мэдээлэл сургалт хийж ажилласан. Аймгийн хэмжээнд хамралт 27,1 хувийн хамралттай байна. | 96,8 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 1.1.7.** Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалтыг сайжруулах, дэмжлэг хяналт, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж халдварын сэргийлэлт хяналтын багийг чадавхжуулах | Орон нутгийн төсөв | Тандалтад хамрагдсан байгууллагын тоо | 18 | 20 | Говийн Оюу хөгжлийг дэмжих сангийн 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр ХӨСҮТ-тэй хамтран зөвлөн туслах багийг орон нутагт авч ажиллуулан Халдварын сэргийлэлт хяналтын багийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор, багийн гишүүдийг чадавхжуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, халдварын тандалтын сайжруулах чиглэлээр СЭМТ, ӨЭМТ,БОЭТ-ийн 60 гаруй эмч, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 30 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд давтан ашиглаж байгаа багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгал, ариутгалын хяналт, халдваргүйжүүлэх бодисын сонголт, халдваргүйжүүлэлтийн үр дүнг хянах агуулгын хүрээнд сургалт зохион байгуулж чадавхжуулсан.<br><br>Эхний хагас жилийн байдлаар 4 хувийн хэвшлийн эмнэлэг, 4 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төвд буюу нийт 11 эрүүл мэндийн байгууллагад халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр дэмжлэгт хийж, албан бичгээр 10 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.<br><br>Сургалтад хамрагдсан халдвар хяналтын ажилтны тоо 90<br>Тандалтад хамрагдсан байгууллагын тоо 11 | 76 |
| | | | Сургалтад хамрагдсан халдвар хяналтын ажилтны тоо | 45 | 45 | | |
| | **Арга хэмжээ 1.1.8.** Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ болон дахин сэргэж буй халдварт | Байгууллагын төсөв | Сургалт үйл ажиллагаанд хамрагдсан эмч | 30 | 50 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ болон дахин сэргэж буй халдварт Улаанбурхан, Хоол хүнснээс шалтгаалсан хоолны хордлогот халдварын чиглэлээр аймгийн хэтийн төлөвийг тооцож, хариу арга хэмжээг төлөвлөсөн. ЭМЯ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өвчний хэтийн төлөв, хандлагыг тооцож бэлэн байдал, хариу арга хэмжээг төлөвлөх, ЭМБ-ын эмч, мэргэжилтнийг чадавхжуулах | | мэргэжилтний тоо | | | ХӨСҮТ хамтран халдварын нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээг хийн хариу арга хэмжээ авч ажилласан. Улаанбурхан өвчний дэгдэлтэй холбоотой 3 удаагийн эрсдэлийн үнэлгээ хийгдэж “дунд” эрсдэлтэй үнэлэгдсэн. Хоол хүнсний шалтгаант хордлогот халдварт өвчний голомтлон гарсан дэгдэлттэй холбоотой 1 удаагийн эрсдэлийн үнэлгээ хийгдэж “дунд” эрсдэлтэй гарч тушаалын дагуу хариу арга хэмжээ зохион байгуулан, тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд идэвхжүүлэн ажилласан. Хоол хүнснээс шалтгаалах халдварт өвчний авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ХӨСҮТ, ЭМЯ-тай 3 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулж, нөхцөл байдлыг тухай бүр нь тайлагнаж, үр дүнг танилцуулсан. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ болон дахин сэргэж буй Улаанбурхан тарилгат халдварт өвчний бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний багийг чадавхжуулах зорилгоор ХӨСҮТ-тэй хамтран нийт 11 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, 22 эрүүл мэндийн байгууллагын 234 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.<br><br>Сургалтад хамрагдсан хүний 234 | |
| | **Зорилт 1.2. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, авчлөлөөс урьдчилан сэргийлэх, сэргийлж болох эндэгдлийг иргэд, хамт олны оролцоотой бууруулж, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг эрчимжүүлэх** | | | | | | |
| | | | Артерийн даралт ихсэх өвчний эрт | 39.3 | 40.3 | Оны эхэнд статистикийн хүн амаас зорилтод бүлгээ өмнө нь оношлогдож хяналтад байгаа, сүүлийн 2-с дээш жил орон нутагтаа амьдрахгүй | 22,8 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 1.2.1.** Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл тухайлбал, хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэлт өвчний эрт илрүүлэх үзлэгт хамралтыг нэмэгдүүлэх. | Орон нутгийн төсөв | илрүүлэг /10 000 хүнд амд/ | | | байгаа иргэдээ хасаж тооцож гаргасан Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих 27416 хүнээс 5911 буюу 21,6 хувь, чихрийн шижингийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 19887 хүнээс 6076 буюу 30,6 хувь хүнийг хамруулсан. Илрүүлэг үзлэгээр шинээр артерийн даралт ихсэх өвчтэй 32, чихрийн шижин өвчтэй 3 тохиолдлыг илрүүлэн хяналтад авсан байна.<br><br>Хөхний өмөнгийн илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих нийт 12159 хүн хамрагдахаас 2992 буюу 24.6 хувь хамрагдсан.<br><br>Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт 5126 хүн хамрагдахаас 669 хүн буюу хамрагдалт 13.1 хувь байна<br><br>Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 150,250 иргэнд үзлэг шинжилгээ хийсний 36,7 %-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн ба өмнөх оноос 4,6% өссөн үзүүлэлттэй байна. | |
| | | | Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг /10 000 хүнд амд/ | 62.6 | 63.6 | | |
| | | | Хөхний хавдрын эрт илрүүлэг | 6448 | 7448 | | |
| | | | Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг /10000 хүнд амд/ | 28.4 | 34.5 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 1.2.2.** Аймгийн хэмжээнд 4,6,8,10,12,14,16 насны хүүхдийн багцын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах | Орон нутгийн төсөв<br>350.0 | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь | 62 | 70 | Аймгийн хэмжээнд 4,6,8,10,12,14,16,17 хүртэлх насны 12243 хүүхдийн судалгааг нэгтгэж урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх “Жаргалтай ирээдүй” төсөл арга хэмжээг аймгийн хэмжээнд 05 дугаар сарын 19-ний өдрөөс эхлүүлсэн. Арга хэмжээнд шаардлагатай 287,714,000 төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн. Үйл ажиллагааны санхүүжилтийн 60% хувийг 17 эрүүл мэндийн байгууллагад олгож, үлдсэн 40%-ийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгохоор шийдвэрлэн ажиллаж байна. Жаргалтай ирээдүй хүүхдийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үзлэгийн бүртгэл, мэдээлэл, тайланг боловсруулах тусгайлсан программыг хөгжүүлэн, холбогдох аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажилласан. Гурвантэс, Булган, Хүрмэн, Баяндалай СЭМТ, Шимбилиг ӨЭМТ Жаргалтай ирээдүй үзлэг эхлүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 214 хүүхэд үзлэгт хамрагдсан бөгөөд үзлэгийн хамрагдалт 2 хувийн гүйцэтгэлтэй байна. Арга хэмжээг 3-4 дүгээр улиралд үргэлжлүүлэн зохион байгуулна.<br><br>Үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй 6 настны эрт илрүүлэг үзлэгийн хувьд нийт 1929 хүүхэд хамрагдахаас зүрхний үзлэгт 1363 /70,6%/, Шүдний үзлэгт 1594/82,6%/, нүдний үзлэг хэрэглэгдэхүүний хүрэлцээгүй байдлаас шалтгаалан 413 /21,4%/ -тай тус тус хамрагдаж байна. | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 1.2.3.** Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг насны бүлгээр хамруулж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг өрнүүлж хамрагдалтыг нэмэгдүүлэх | Орон нутгийн төсөв | Эрт илрүүлгийн хувь | 36.5 | 45.0 | Эрүүл мэндийн сайдын 379 дүгээр тушаалын хүрээнд зохион байгуулагдаж буй эрт илрүүлэг үзлэгийн хамралт хагас жилийн байдлаар 30382 /40.5%/, 0-17 насанд 18977 /67,8%/, 18-дээш 11405 /24,2%/ хамрагдалттай байна. Насан хүрэгчдийн хамрагдалт муу байгаатай холбоотой 1-4 дүгээр саруудад Жасминдратай гэрээлэн хамтран ажиллаж 1200 иргэнийг хамруулсан. Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эрт илрүүлгийн дэмжих төвийн хүчин чадал, багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлсэн. БОЭТ-ийн дэмжих төвийг бүрэн тохижуулж өдөрт 50-60 иргэнд түргэн шуурхай, тав тухтай үйлчилгээ авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн эрт илрүүлэг хийх эмч мэргэжилтний нөөцийг нэмэгдүүлэн 2 ходоодны дуран, 2 дурангийн эмч, 1 сувилагч ажиллаж байна. Хагас жилийн байдлаар эрт илрүүлгийн төвд 891 хүн хамрагдсан байна. Эрт илрүүлгийн үр дүнд хоол боловсруулах замын эмгэгтэй 236 хүн, зүрх судасны өвчтэй 76 хүн, бөөр шээсний замын өвчтэй 86 хүн, БЗДХ өвчтэй 6 хүн, дотоод шүүрлийн өвчлөлтэй 82 хүн, элэгний вирустэй 58 хүнийг тус тус илрүүлэн хяналтад авч, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хавдрын үүсгэвэр тодорхойлогдсон 25 хүнийг лавлагаа шинжилгээнд бүрэн хамруулсан. | 90 |
| | **Арга хэмжээ 1.2.4.** Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, | Орон нутгийн төсөв | Хүрч үйлчилсэн хүний тоо | 4815 | 5000 | "Өнөөдрийн хяналт- Ирээдүйн хамгаалалт" уриан дор явуулын үзлэг арга хэмжээг 6 суманд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаа. Эхний хагас жилийн байдлаар Ноён, Гурвантэс суманд | 22,1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, эмчилгээг зохион байгуулах | 300.0 | | | | үзлэг арга хэмжээг зохион байгуулсан. Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хамтарсан баг эмэгтэйчүүд, гэмтэл, нүд, чих хамар хоолой, арьс харшил, халдварт өвчин, дотор, эхо гэсэн 8 чиглэлийн дагуу 1106 иргэнд үзлэг, оношилгоо зохион байгуулсан. Нийт хамрагдсан иргэдийн 26.1% малчин иргэн байсан. Үзлэг арга хэмжээний үр дүнд үзлэгээр илэрсэн өвчлөлийн 10,3 хувийг лавлагаа шатлалд шилжүүлсэн. Мөн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр Сургууль цэцэрлэгийн хүүхдүүд, багш ажилчид, 11 настай хүүхдүүдийн асран хамгаалагчдад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулж нийт 748 иргэнийг хамруулсан байна. Явуулын үзлэг арга хэмжээнд шаардлагатай эм, урвалж оношлуур худалдан авах тендерийн үйл ажиллагаа удаа дараа зарлан, амжилтгүй болсонтой холбоотойгоор дараагийн сумдад ажиллахад эм, урвалжийн нөөц хүрэлцээгүй болсон. Энэ оны 3,4 дүгээр улиралд Цогтцэций, Хүрмэн, Мандал-Овоо, Ханхонгор сумдад зохион байгуулахаар төлөвлөж байна. | |
| | **Арга хэмжээ 1.2.5.** Хавдрын хими, бай эмчилгээ, хавдрын эрт илрүүлгийг орон нутагт зохион байгуулах | Орон нутгийн төсөв<br>100.0 | Эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо | 26 | 40 | Аймгийн хэмжээнд хорт хавдраар оношлогдсон нийт 622 тохиолдлыг хянан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “Хавдрын хими эмчилгээний хэсэг"-ийн үйл ажиллагааг тогтмолжуулан хагас жилийн байдлаар хөнгөвчлөх эмчилгээнд 59 хүн, хавдрын хими эмчилгээг 12 хүн давхардсан тоогоор нийт 31 удаагийн хавдрын хими, бай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2 | | | | | | эмчилгээг 6 хүнд 10 удаагийн тусламж үйлчилгээг тус тус хүргэсэн байна. Хавдрын тусламж үйлчилгээний чиглэлээр Хавдар судлалын үндэсний төвийн эмч мэргэжилтнүүдтэй хамтран үндэсний баг үзлэг арга хэмжээг зохион байгуулан 233 хүнийг лавлагаа шатлалын үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулсан. Арга хэмжээний хүрээнд БОЭТ-ийн Хавдрын эмч, Ангиографийн эмч нар ажлын байрны дагалдан сургалтад хамрагдаж чадавхжсан. БОЭТ-ийн дотрын тасгийн 2 сувилагчийг Хавдар судлалын үндэсний төвд хавдрын хими, бай, хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр 1 сарын хугацаатай ажлын байрны дагалдан сургалтад хамруулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангасан. Мөн Хөнгөвчлөх эмчилгээний эмчээр богино хэмжээний сургалтад 1 эмч хамрагдаж байна. Хавдрын хими, хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдаж буй иргэдэд долоо хоног бүрийн лхагва гаригт 11-12 цагийн хооронд хөгжимт засал эмчилгээг уламжлал болгон зохион байгуулж байна. Шим билэг, Гурвантэс, Цогтцэций, БОЭТ-д умайн хүзүүний өвчлөл, хавдрыг эрт илрүүлэх колькоскоппыг ашиглан 96 хүнд тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Үзлэгээр умайн хүзүүний хавдрын урьдал байх магадлалтай 15 хүн буюу нийт үзлэгийн 15,6%-эсийн шинжилгээнд хамруулсан байна. Үүнээс умайн хүзүүний хавдрын урьдлаар 2 хүн оношлогдож шаардлагатай эмчилгээ, зөвлөмжийг хүргүүлэн хяналтад авсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ажлын байрны дагалдан сургалтад хамруулсан эмч, мэргэжилтний тоо – 4<br>Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо - 59<br>Хими эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо-12 хүнд 41 удаа<br>Бай эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо – 6 хүнд 10 удаа | |
| | **Арга хэмжээ 1.2.6. *“Эрүүл шүд”*** хөтөлбөрийг хэрэгжүүлж, амны хөндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх. | ОНТөсөв<br>700.0 сая төг | Амны хөндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо<br>Эмчлэн эрүүлжүүлсэн тоо | 35430<br>23029 | 36000<br>24000 | “Эрүүл шүд” хөтөлбөрийн төслийг боловсруулан АИТХ-н хурлаар батлуулсан. Хөтөлбөрийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд нийт 17 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 8 суманд /ГТ, МН, НН, НО, ХБ, ЦЦ, СЭ, БО/ шүдний тусламж үйлчилгээг хүргэж, 2 суманд кабинет байгуулагдаад байна. Нийт хувийн хэвшлийн 8 шүдний эмнэлэг, Говь дент төв, БОЭТ зэрэг нийт 18 кабинетаар амны хөндий, шүдний тусламж үйлчилгээг нийт 10,202 хүнд хүргэсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад тусламж үйлчилгээ хүргэсэн хүний тоо 4.6 хувиар нэмэгдсэн байна. Говь дент анхны цахиур ОНӨААТҮГ Хагас жилийн байдлаар 5078 иргэнд амны хөндийн тусламж үйлчилгээ, 1254 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг үнэ төлбөргүй зохион байгуулж ажиллаа. Мөн сар бүр дэмжих аяныг зохион байгуулж хүүхдэд ээлтэй сар, онцгой сар, эмч нарын сар, сургалтын сар, сувилагч нарын сар, тусгай хэрэгцээт хүүхдийн сар болгон зорилтот бүлгийн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэсэн. Орон нутгийн хэмжээнд 24/3 шүдээ угаа аяныг сум, өрх бүр зохион байгуулж, нийт 6005 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг, фтор түрхлэг хийсэн ба үзлэгээр цоорлын тархалт 82%, цоорлын эрчим 4.5% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээнд 19849 иргэн, хүүхэд өсвөр үеийнхэн хамрагдсан байна. | |
| | **Арга хэмжээ 1.2.7.** Алслагдсан сумдад амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгоо, эмчилгээний Явуулын баг ажиллуулан урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Амны хөндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо | 9445 | 10000 | Аймгийн хэмжээнд шүдний эмч, шүдний кабинетгүй 8 сумын эрүүл мэндийн төвд 4 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулсан. Гэрээ дагуу алслагдсан 8 сумын 145 хүүхдэд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд сумдад амны хөндийн тусламж үйлчилгээг хүргэсэн.<br>Явуулын амны хөндийн тусламж үйлчилгээг 3,4 дүгээр улиралд алслагдсан сумд зохион байгуулахаар төлөвлөж байна. | 70 |
| | **Арга хэмжээ 1.2.8** Даланзадгад сумын Ерөнхий боловсролын сургуулиудын шүд угаах хэсгийг байгуулж байнгын ашиглалтад оруулах | Орон нутгийн төсөв<br>280.0 | Шүд угаах хэсэг байгуулсан сургуулийн тоо | - | 4 | Аймгийн Засаг даргын а/63 дугаар захирамжийн дагуу шүд угаалтын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх, ажлын байрандаа шүдээ тогтмол угаах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор одоогийн байдлаар 15 байгууллага "шүд угаах хэсэг" байгуулсан. Мөн Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлэхээр Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Даланзадгад сумын ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургууль дээр тус бүр 4 шүд угаах буланг, “Говийн Оюу Хөгжлийг дэмжих сан” -гийн санхүүжилтээр ЕБС-ийн 1, 2, 5 дугаар сургууль, Цогтцэций сумын 2 дугаар сургууль, Гурвантэс, Сэврэй, Цогт-Овоо сумын ерөнхий боловсролын нийт 9 сургууль шүд угаах буланг тохижуулсан Ингэснээр 10,502 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийн шүд угаах орчин нөхцөл бүрэн хангагдсан. | |
| | **Арга хэмжээ 1.2.9** Осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт)-д анхаарч салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх | Орон нутгийн төсөв | 100000 хүн амд осол гэмтлийн шалтгаант өвчлөл | 216.8 | 215 | 5 сарын байдлаар 648 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба өвчлөл өнгөрсөн оноос 131 тохиолдлоор буурсан байна. Хүүхдүүдийн дунд 114 осол гэмтлийн тохиолдол бүртгэгдсэн байна. Осол гэмтэлд өртсөн байршлыг авч үзвэл 42,8% гэртээ, 34.2%-гудамж зам, 5,1% сургууль цэцэрлэгийн орчинд тохиолдсон нь өнгөрсөн оноос гэрийн орчин дахь осол гэмтэл буурч, гудамж замын осол нэмэгдсэн байна. Оны гарсаар 142 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 16,9% нь хорт хавдраар, 32,4% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдлээр, 15,5% нь осол гэмтлээр, 2,8% нь чихрийн шижин өвчнөөр тус тус нас барсан байна. Нийт нас баралтын 33,8% нь эмнэлэгт, 66.2% нь гэртээ, хээр, гадаа нас барсан байна.<br><br>Осол гэмтлээс сэргийлэх “Агшин бүрд анхаарлаа нэмж - Эрсдэлийг бууруулъя” аяны хүрээнд амилуулах суурь тусламжийн сургалтад 68 иргэнийг, ахуйн осол гэмтлээс сэргийлэх сургалтад 380 иргэнийг хамруулсан бөгөөд сургалтыг үргэлжлүүлэн хийж байна. | 100 |
| | **Арга хэмжээ 1.2.10.** Салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот арга хэмжээ (“Эрүүл монгол хүн”, “Халдварт өвчнөөс | Улсын төсөв | Арга хэмжээний дундаж хэрэгжилтийн хувь | 90.0 | 92.0 | Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлээр аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 10 төрлийн | 60 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх хянах”, “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх”, “Сэтгэцийн эрүүл мэнд” 2024-2027)-г үр дүнтэй хэрэгжүүлэх | | | | | төсөл арга хэмжээг тусган шаардлагатай 1.8 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлсэн.<br><br>“Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө” -г батлуулан төрийн өмчийн 22 эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 52 үйл ажиллагаа төлөвлөгдсөн хэрэгжилт тооцох хугацаа болоогүй.<br><br>Аймгийн хэмжээнд аутизмтай 11 хүн бүртгэлтэй байна. Насны хувьд 2-48 насны хүмүүс байгаа бөгөөд насны бүлгээр 10-48 настай 2, 2-8 настай 9, хүйсээр эрэгтэй-9, эмэгтэй-2 байна. 2025 онд БОЭТ-ийн сэтгэцийн эмч шинээр 2 хүүхэд илрүүлж оношилсон. СЭМҮТ-д онош баталгаажуулахаар илгээсэн боловч 6 настайд дахин үнэлгээг хийнэ гэж буцаасан байна.<br><br>“Сэтгэцийн эрүүл мэнд” чиглэлээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хавдар, хөнгөвчлөх эмчилгээний тасгийн үйлчлүүлэгч 2 иргэнд сэтгэл гутрал, сэтгэл түгшилт сэдвээр 2 удаагийн зөвлөгөө өгсөн.<br><br>Төрийн 5 албан байгууллага, хувийн 1 байгууллагад “Стрессийн тухай ойлголт, уур бухимдлаа зохицуулах нь, стрессийг даван туулах арга зам сэдвээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 136 хүнд хүргэсэн.<br><br>Итгэлтэй амьдрал төвийн эмч мэргэжилтнүүд Цогтцэций, Сэврэй, Ханхонгор, Гурвантэс сумын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн өмнөх боловсролын багш ажилчид, асран | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамгаалагчдад, ЕБС-ийн 6-12 ангийн суралцагчдад “Стрессээ зохицуулж, өөрийгөө удирдахуй”, “Сэтгэл хөдлөлөө хянах нь”, хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх, ээрэг мэдрэмжийг түгээх бүлгийн зөвлөгөөг нийт 209 хүнд хүргэж, судалгааг авсан байна.<br><br>Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Дугуйтай аян, Завсарлагааны хэмнэл аян, Шүдээ угаах 24/3 аян зэрэг томоохон аяныг зохион байгуулж Мөн аймгийн хэмжээнд сар бүр “Эрүүл мэндийг дэмжих өдөр” арга хэмжээг төлөвлөн 1 сарыг архины согтуурахтай тэмцэх, 2 сарыг Осол гэмтлээс сэргийлэх, 3 сарыг Давсны хэрэглээг бууруулах, 4 сарыг Дэлхийн эрүүл мэнд, 5 сарыг Тамхины эсрэг сар болгон нийт 110 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг хийж 4,146 хүнд хүрч ажилласан байна. | |
| | **Арга хэмжээ 1.2.11.** Бага насны хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдлаас хамгаалах, өсөлт хөгжилтийг дэмжих зорилгоор ***“Сүү тараг”*** хөтөлбөрийг хэрэгжүүлэх | ОНТөсөв<br><br>250.0 сая төг | Зорилтод бүлгийн хүүхдийн хамралтын хувь | 85 | 90 | Аймгийн хэмжээнд Сүү тараг хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 зорилтын 10 арга хэмжээг төлөвлөн батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 65 хувьтай. Хөтөлбөрийн хүрээнд хамрагдвал зохих 6-12 сартай 4106 хүүхэд, 2 хүртэл насны ихэр 268 хүүхэд, 12 хүртэл насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1561 хүүхэд, жингийн алдагдалтай, 12-24 сартай жингийн алдагдалтай өсөлтийн хоцролттой 834 хүүхэд буюу нийт давхардсан тоогоор аймгийн хэмжээнд 6769 хүүхдийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. “Сүү тараг” хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоогоор санхүүжилтийг харьяа сумын Засаг даргын Тамгын газарт эрхийг шилжүүлэн | 65 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 186,147,500 сая төгрөг санхүүжилтийг олгож ажилласан.<br><br>Сумын эрүүл мэндийн төвүүд 5 дугаар сард Сүү тараг хөтөлбөрийн үйл ажиллагааг эхлүүлж 14 сумын хамрагдах ёстой 1132 хүүхэд 100% амжилттай хамрагдаж байна. Нэг хүүхдэд сард ноогдох санхүүжилт 27,500 төгрөгөөр тогтоож, сард 4 удаа олгож, нэг удаагийн авалтаар 650 гр тараг, 600 гр сүү эцэг эх, асран хамгаалагч нарт хуваарийн дагуу олгон ажилласан. Даланзадгад сумын “Сүү тараг” хөтөлбөр 6 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна. Даланзадгад суманд нийт 3541 хүүхэд хамрагдахаар судалгааг гаргаад байна. | |
| | **Арга хэмжээ 1.2.12.** Аймгийн иргэдийн ирүүл мэндийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх | Төсөл хөтөлбөр<br><br>1.500.0 | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85 | 95 | Говийн Оюу Хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр “Өмнөговь аймгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр”-ийг 2024-2025 онд хэрэгжүүлэн ажиллахаар ажлын төлөвлөгөөнд 19 ажил арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 2025 оны хагас жилийн байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 99.0 хувьтай хэрэгжиж байна. Бүрэн хэрэгжиж дууссан 18 арга хэмжээ, хэрэгжиж буй 1 арга хэмжээ байна. Нийт авсан санхүүжилтийн 90 гаруй хувийг зарцуулсан байна. Худалдан авах арга хэмжээний биелэлт 100%-тай хэрэгжсэн.<br><br>2025 онд 28 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ГОХДС-аас 1.5 тэрбум төгрөгийн төсвийг шийдвэрлэсэн. Санхүүжилтийн 60%-аас дээш хувь хөрөнгө оруулалтын зардалд зарцуулахаар төсөвлөгдсөн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Арга хэмжээ 1.2.13.** Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан хүний тоо | - | 5000 | Төрийн 5 албан байгууллага, хувийн 1 байгууллагад "Стрессийн тухай ойлголт, уур бухимдлаа зохицуулах нь, стрессийг даван туулах арга зам сэдвээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 176 хүнд хүргэсэн. Мөн Итгэлтэй амьдрал төвийн эмч мэргэжилтнүүд Цогтцэций, Сэврэй, Ханхонгор, Гурвантэс сумын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн өмнөх боловсролын багш ажилчид, асран хамгаалагчдад, ЕБС-ийн 6-12 ангийн суралцагчдад "Стрессээ зохицуулж, өөрийгөө удирдахуй", "Сэтгэл хөдлөлөө хянах нь", хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх, эерэг мэдрэмжийг түгээх сэтгэл зүйн бүлгийн зөвлөгөөг нийт 209 хүнд хүргэж, судалгааг авсан байна. Ерөнхий боловсролын 10 сургууль, 1 политехник коллежийн 6-12 дугаар ангийн нийт 1350 сурагч, 12 ААНБ-н 300 ажилтанд "Тамхи хэрэглээний өнөөгийн байдал, Янжуур ба электрон тамхины хор хөнөөл" сэдвээр танхимын сургалт зохион байгуулсан. Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төв дээр мэргэжлийн сэтгэл зүйч орон тоогоор ажилссанаар 9 иргэн, өсвөр насны 5 хүүхдэд 60 гаруй удаагийн давтамжтайгаар ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг өгсөн.<br><br>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хавдар, хөнгөвчлөх эмчилгээний тасгийн үйлчлүүлэгч иргэдэд сэтгэл гутрал, сэтгэл түгшилт сэдвээр 2 удаагийн зөвлөгөө өгч ажилласан. "Итгэлтэй амьдрал төв"-өөр архинд донтох эмгэгтэй үйлчлүүлэгч нарт амбулаториор 199, хэвтэн эмчлүүлсэн 139 хүн байна. Үйлчилгээнд хамрагдсан хүний 70% архины эмчилгээ, 17% | 48 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нойргүйдэл, 7% сэтгэл гутрал, 6% сэтгэл түгших эмчилгээнд хамрагдсан.<br><br>Архинд донтох эмгэгтэй үйлчлүүлэгчийн архины давхар хамааралтай ар гэрийнхэнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээг 349 хүнд давхардсан тоогоор хүргэсэн байна.<br><br>Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан хүний тоо -2434 | |
| | **Арга хэмжээ 1.2.14.** Ахмадуудын дунд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | Орон нутгийн төсөв | Зорилтот бүлгийн хамрагдсан хувь | 70 | 75 | Эрүүл мэндийн яамнаас 2025 оны 2 дугаар сарыг “Ахмад настны эрүүл мэндийг дэмжих сар“ болгон зарласантай холбоотой Даланзадгад сумын ЗДТГ, ЭМГ, БОЭТ-тэй хамтран ахмад настны эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, эрүүл урт наслах амьдралын чанарыг сайжруулах зорилгоор 10 багийн төв дээр үзлэг оношилгоог зохион байгуулсан. Үзлэгт нийт 798 ахмад настан хамрагдан 7 чиглэлийн эмчийн үзлэгт /ЭХО-814, ЭКГ-629, зүрх судас-516, ахмад настан-102, нүд-749, чих хамар хоолой-585, арьс харшил-534, сүрьеэ-701/ давхардсан тоогоор 4630 үзлэг хийгдсэн.<br><br>Үзлэгээр үр дүнд элэгний хавдрын тохиолдол 4, сүрьеэгийн сэжигтэй тохиолдол 2, хурц мухар олгойн үрэвсэл-1, нүдний хурц даралт ихсэлт 4 илрүүлж лавлагаа 3-р шатлалд 5, орон нутагтаа БОЭТ-д онош тодруулахаар багажийн болон бусад шинжилгээнд 126 хүнийг илгээсэн байна.<br><br>“НАРТА ЧОЙНЖИН” төрийн бус байгууллагатай хамтран Даланзадгад сумын 10 багийн 242 ахмад настанд “Эрүүл насжилт, идэвхтэй хөдөлгөөн, зохистой хооллолт” сэдвээр сургалтыг зохион байгуулж, ICOPE үнэлгээний | 84,6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу хөдөлгөөний чадавх бууралтыг илрүүлэх сорилын үнэлгээг хийсэн. Тус үнэлгээгээр 23,9% нь хөдөлгөөний чадвар бууралттай, 69,3% нь артерийн даралт өндөр, 61,5% нь өдөр тутамдаа тогтмол 3-4 эм ууж хэрэглэдэг болох нь тогтоогдсон.<br><br>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ахмадын кабинетаар 2025 оны 5 дугаар сарын байдлаар нийт үзлэг 3266 үүнээс өвчний учир 2741, идэвхтэй хяналтад 525 үзлэг хийж кабинетаар үйлчилсэн**.**<br><br>Зорилтот бүлгийн байнгын хяналтад байдаг ахмад-943 байгаагаас үүнээс тусламж үйлчилгээнд хамруулсан 798 байна. | |
| | **Арга хэмжээ 1.1.15.** Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулах | Орон нутгийн төсөв<br><br>100.0 | Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээ<br><br>Хамрагдсан хүн ам | 20<br><br>500 | 20<br><br>1000 | Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 70%-ийн биелэлттэй, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. Аймгийн 22 эрүүл мэндийн байгууллага ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт нөлөөллийн 40 гаруй арга хэмжээг зохион байгуулж 11000 гаруй иргэнийг хамруулсан. Бусад салбарын хамтын ажиллагааны хүрээнд нийт 60 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын фейсбүүк хуудсаар дамжуулан 1500 төрлийн мэдээлэл, нийтлэлийг хүргэж давхардсан тоогоор 350,000 хүний хандалт авсан.<br><br>Өмнөговь аймгийн Засаг даргын санаачилсан "Электрон тамхинаас татгалзаж, ирээдүйгээ хамгаалцгаая" аяныг 1 сарын хугацаанд зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагдан аянд хамтарч ажилласан. Аяны хүрээнд 3 сум, 6 сургуулийн 1000 орчим сурагчдад электрон тамхины хор хөнөөлийн талаар сургалтыг зохион байгуулсан.<br><br>Аймгийн хэмжээнд Дугуйтай аян, Завсарлагааны хэмнэл аян, Шүдээ угаах 24/3 аян зэрэг томоохон аяныг зохион байгуулж Мөн аймгийн хэмжээнд сар бүр “Эрүүл мэндийг дэмжих өдөр” арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж нийт 110 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг хийж 4146 хүнд хүрч ажилласан байна. Нийтийн биеийн тамирыг дэмжих чиглэлээр аймгийн 43 спорт заал, 2 усан бассейн, 5 фитнес клуб, 4 иог, бясалгалын төв, 2 бүжгийн клуб зэрэг нийт 56 байгууллага аж ахуй нэгжтэй хамтран хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжин ажиллаж байна.<br><br>МСС-д хамрагдсан байгууллагын тоо-110<br><br>МСС хамрагдсан иргэдийн тоо-4146 | |
| | **Арга хэмжээ 1.1.16** Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад халдварт бус өвчин, тэр дундаа зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц МонПЭН болон мобайл технологи | Орон нутгийн төсөв | Мобайл технологийн ашиглалтыг хувь | 80 | 90 | Сумын 14 эрүүл мэндийн төв, 3 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл технологийг ашиглаж байна. Аймгийн хэмжээнд 5 сарын байдлаар 46,289 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15,688 тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 67,5% нь шинэ өвчлөл байна.<br><br>Өвчлөлийн тэргүүлэх шалтгааны 3-рт Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-3373 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 356 тохиолдлоор | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавих | | | | | нэмэгдсэн байна. “Говийн оюу” хөгжлийг дэмжих сангийн дэмжлэгээр “Өмнөговь аймгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр” 2025 арга хэмжээний хүрээнд “Эрүүл зүрх” арга хэмжээг 7 суманд зохион байгуулахаар төлөвлөгдсөн. Дээрх сумуудад зохион байгуулагдах үзлэг арга хэмжээнд мобайл технологийг бүрэн ашиглаж үр дүнг тооцож ажиллахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн сургуулийн 6 настай хүүхдийн зүрхний үзлэгт 1929 хүүхэд хамрагдахаас 1383 хүүхэд хамрагдаж хамрагдалт 71.7%-тай байна. Зүрхний цахилгаан бичлэгээр 201 тохиолдол өөрчлөлттэй гарсан тул цаашид БОЭТ-д 3-р шатлалын нарын мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулахаар төлөвлөгдсөн. | |
| | **Арга хэмжээ 1.2.18.** Өсвөр үе залуучуудын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллах, эрүүл мэнд, бэлгийн боловсрол олгох цогц сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан өсвөр үеийн тоо | 3520 | 5000 | Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" сэдэвт өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих сарын аяны арга хэмжээг зохион байгуулж нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг эрчимжүүлсэн. Аяны хүрээнд Эрүүл мэндийн газрын цахим хаягаар иргэдэд мэдээлэл хүргэж, Дархлаажуулалтын 7 хоногийн аянтай хамтран Даланзадгадын 6 сургуулийн 3000 хүүхдэд өртөөчилсөн мэдээлэл хүргэж танин мэдэхүйн асуумжаар мэдлэг, ойлголтыг бататгаж ажилласан. Зөв, зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөний дадал эзэмшүүлэх, бэлгийн бойжилт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, хорт бодисын хэрэглээ, хүчирхийллийн улмаас тохиолдож буй бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх, эрсдэлт зан үйлээс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | татгалзах арга ухаанд суралцахад нь туслах чиглэлээр Ноён, Гурвантэс сумын 6-12 дугаар ангийн нийт 500 сурагчид сургалт мэдээллийг хүргэж "Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 23 сургуулиудын сурагчдын эрүүл мэндийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, эрүүл зан үйл, дадал хэвшлийг төлөвшүүлж, хүүхэд нэг бүрийг эрүүл, аюулгүй амьдрахад хувь нэмэр оруулах зорилгоор Эрүүл мэндийн массын олимпиадыг зохион байгуулж Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа VI-XII ангийн 2794 суралцагч, эрүүл мэндийн хичээл зааж буй 56 багш нийт 2850 хүнд амжилттай оролцож, сурагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн ажилласан.<br><br>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн өсвөр үеийн кабинет 2025 оны 5 сарын байдлаар 498 хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж өсвөр үеийнхний дунд бэлгийн замаар дамжих халдварын 24 тохиолдол, умайн хүзүүний үрэвсэл болон бусад үрэвслийн шалтгаант өвчлөлтэй холбоотой 22 тохиолдлыг тус тус эмчлэн эрүүлжүүлсэн. | |
| | **Арга хэмжээ 1.2.19.** Эрэгтэйчүүдэд чиглэсэн нийгмийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг | Орон нутгийн төсөв | Кабинетаар үйлчлүүлсэн эрэгтэйчүүдийн тоо | 860 | 1000 | Цэргийн албаны татлагын эрүүл мэндийн үзлэгээр өвчний улмаас цэргийн албанд тэнцээгүй 245 иргэнээс Халдварт өвчин-9, бусад өвчлөл-236 байна.<br><br>Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт Өмнөговь аймгийн 18-87 насны нийт 11405 хүн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэх | | | | | хамрагдсан бөгөөд тэдний 34.1% (n=3891) эрэгтэйчүүд, 65.9% (n=7514) эмэгтэйчүүд байна.<br><br>урологи-андрологийн кабинетад 26 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс 16 хүнд мэс ажилбар хийсэн байна. | |
| | **Арга хэмжээ 1.2.20.** Олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг сургаж чадавхжуулах, тэдгээрээр дамжуулан эрүүл мэндийн хүрч очих үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | Орон нутгийн төсөв | Хүрч үйлчилсэн иргэдийн тоо | - | 1000 | Өмнөговь аймгийн эрүүл мэндийн салбарт олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг ажиллуулах, урамшуулах, удирдлага зохион байгуулалтын асуудлыг тусгасан журмын төсөл, 2025 онд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулж НҮБ-н Хүүхдийн санд хүргүүлсэн. Хүүхдийн сангаас Өмнөговь аймагт олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг ажиллуулах, урамшуулах тогтолцоог улсын хэмжээнд загвар байдлаар нэвтрүүлэхээр хамтран ажиллаж байна. Аймгийн хэмжээнд бэлтгэгдсэн 30 олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудын уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан. Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр ОНЭМА-ыг давтан бэлтгэх ажлыг 3,4-р улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна.<br><br>Өнө-орших, Ноён, Сэврэй сумын ЭМТ-ийн НЭМА-нууд 2024 онд бэлтгэгдсэн ОНЭМА-наа ажлуулан зорилтод бүлгийн /вакцин хамрагдах бага насны хүүхэд, жирэмсэн, ахмад настан/ 250 хүнд хүрч үйлчилсэн байна. | 25 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
